



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/665

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Хөгжил политехник коллеж, Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Мянгад сумын Чацарганат багийн төвийн ширээ сандал шинэчлэх зардалд 16 939 820 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 16 939 820 төгрөг /Арван зургаан сая есөн зуун гучин есөн мянга найман зуун хорин/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 оны батлагдсан төсвийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын 08-ны өдрийн  
А/665 дугаар захирамжийн хавсралт



ХОВД АЙМГИЙН ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ, БУЛГАН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1-12 ЖИЛИЙН СУРГУУЛЬ,  
МЯНГАД СУМЫН ЧАЦАРГАНАТ БАГИЙН ТӨВИЙН  
ШИРЭЭ САНДАЛ ШИНЭЧЛЭХ ТӨСӨВ

Д.д	Хувиарлах сургууль	Бараа материал үнэт зүйлийн нэр төрөл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Хөгжил Политехник коллеж.	Ширээ	ш	40	99,646	3.985,84
2.		Сандал	ш	80	49,823	3.985,84
3.	Булган сумын ерөнхий боловсролын 1-12 жилийн сургууль	Ширээ	ш	30	99,646	2,989.38
4.		Сандал	ш	60	49,823	2,989.38
5.	Мянгад сумын Чацарганат багийн төв	Ширээ	ш	15	99,646	1,494.69
6.		Сандал	ш	30	49,823	1,494.69
ДҮН		Ширээ	ш	85		16,939.82
		Сандал	ш	170		

-oOo-